

**Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг
нэхэн сурвалжлах нь**

Докторант П.Дэлгэржаргал /МУИС/

Түрэг угсааны улсууд Монгол нутагт ноёрхож байх үе /VI-X зуун/-д Монгол угсааны аймгуудын түүх нэн бүдгэрэн, сурвалж бичигт бараг тэмдэглэгдэхээ больжээ. Харин "Судрын чуулган"-ы "Эргүнэ күн"-гийн домог нь энэ үеийн Монгол аймгуудыг түүхийг тодруулахад чухал учир холбогдолтой. Иймд судлаачид уг домогт ихээхэн анхаарал тавьж, "Эргүнэ күн" хаана байгааг тодруулах гэж нэлээд хүчин чармайлт гарган, хэд хэдэн хувилбар санал дэвшүүлсэн ч эдүгээ хүртэл нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, үндэслэл сайтай үзэл баримтлал болон түүх бичлэгт тогтоогүй, маргаантай асуудал хэвээр байна. Энэхүү ээдрээтэй нарийн асуудлыг шийдвэрлэхэд өчүүхэн боловч тус дэм болохыг чармайн, энэ үеийн Монгол аймгуудын түүхийг тодруулахыг зорьж, Мэнгу /Монгол/ шивэй болон Шивэй аймгуудын угсаа түүхийн талаар зарим нэг санаа дэвшүүлэхийг оролдов.

"Эргүнэ күн"-гийн түүхэн домог нь нэгдүгээрт, Монгол, Түрэг угсааны аймгууд айлсан зэрэгцэн оршиж байгаад нэгэн удаагийн томоохон дайнд Монгол аймгууд ялагдсан тухай, хоёрдугаарт, зөвхөн цөөн хүмүүс буюу овог аймаг /Хиан, Никус / зугтан, эргэн тойрон уул, хад, ой модоор хүрээлэгдсэн гаднаас ганцхан давчуу зөрөг замаар нэвтрэн орох бөглүү газар /бартаатай бөглүү газар гэсэн утгыг илтгэнэ/ очин суусан тухай, гуравдугаарт, тэндээ 400-гаад жил суун өнөржин олшроод, "Эргүнэ күн"-гээс нүүдэллэн гарсан тухай өгүүлсэн байдаг.¹ Чингис хааны өвөг дээдэс уугуул нутаг Онон мөрний эх Бурхан Халдун ууланд ирж байгаагаар "Монголын нууц товчоо" /цаашид МНТ/ эхэлдэг. Ихэнх судлаачид "Эргүнэ күн"-гийн домгийн төгсгөл, МНТ-ны эхлэл хоёрыг холбоотой, өөрөөр хэлбэл, "Эргүнэ күн"-гээс гарсан Монгол угсааны аймгууд Онон мөрний эх Бурхан Халдун ууланд ирж байгаар МНТ эхэлж байна хэмээн үздэг.²

Монгол нутагт Түрэгийн хаант улс ноёрхож байх үед Шивэй аймгуудын дотор Мэнгу, Мэнг ва нэрээр Хятад сурвалжид тэмдэглэгдсэн нэгэн аймаг гарч ирснийг Монгол гаралтай аймаг хэмээн олон эрдэмтэд үзэж, анхаарлаа хандуулжээ. "БНМАУ-ын түүх"-ийн I ботид "... дорнод ху нараас гаралтай сяньби нарыг шивэй аймгуудын дээдэс гэж эрдэмтэд үзэх болжээ. Энэ учраас шивэй нарыг монгол угсааны гарал үүсэлтэй нягт холбон үзэх нь зүйтэй." хэмээн шивэй нарыг бүгд Монгол гаралтай гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлжээ.

Нэрт эрдэмтэн Х.Пэрлээ "Хятан нар тэдний Монголчуудтай холбогдох нь" нэгэн сэдэвт зохиолдоо: "Сүй улсын түүх"-нд "өмнүүр нутаглагсдыг Хятан, хойгуур нутаглагсдыг Шивэй" гэж байв, "Шивэй нарын ... аж ахуй нь цөм Хятантай нэг /адил/ болно", "...Шивэй нарын аливаа хэв заншил ...нь цөм Хятантай дэмий л ялгаагүй" хэмээсэн болон "Ляо улсын түүх"-нд "Тэдний /Хятан Шивэйн/ хэв заншил ... харилцан дэмий л ялгаагүй ...", "Шивэй ... Хятан улсын умар этгээдэд бий .. үг хэл нь Кумоси, Хятан, То-му-лу-нуудтай адил", "...тэдний /Хятан Шивэйн/ ... үг хэл харилцан дэмий л ялгаагүй..." хэмээн тэмдэглэснийг үндэслэн, Шивэй нарыг Хятантай угсаа гарал нэгтэй Монгол аймгууд хэмээн нотолжээ.³ Тэрээр Хятан, Шивэй нарыг Ляоси Сяньби нараас гаралтай хэмээн нотлохын сацуу Мэнгу шивэйг Монгол, Дай/Да/ шивэйг Тайчууд гэсэн саналыг дэвшүүлэн энэ хоёр нийлэн, Хамаг Монгол болсон хэмээн үзжээ.⁴ Х.Пэрлээ гуайн дэвшүүлсэн дээрх саналд олон үнэтэй санаа байгаа ч зарим дүгнэлтүүдийг нягтлан үзэх шаардлага тавигдаж байна. Хэдийгээр Хятад сурвалжуудад Хятан,

Шивэй нарыг угсаа гарал нэгтэй хэмээн хэлж болохуйц зарим нэг баримт байдаг боловч Шивэй аймгуудын аж ахуй, ёс заншил, соёлын талаар өгүүлсэн сурвалжийн ихэнх мэдээ Шивэй нарыг Монгол гаралтай биш болохыг баталж байна. Тухайлбал, "Вэй улсын судар" /Вэй шү/-г Шивэй аймгуудын тухай хамгийн анх тэмдэглэгдсэн бөгөөд Шивэй нарыг "Зун болбоос сууцандаан суурьшиж, өвөл болохоор бэлчээр дагаж нүүдэллэнэ" хэмээн тэмдэглэжээ. Түүнчлэн Шивэй нар буудай ба Монгол амууг тарьж, хөрөнгө хийж архи нэрдэг. Голдуу гахай загас идэж, үхэр адуу тэжээдэг. Харин ерөөс хонь ямаа үгүй. Тэдний ан гөрөөнд хэрэглэдэг багаж зэвсэг нь маш урт сумтай, эврээр матаж хийсэн нум юм. Шивэйчүүд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй цөм цагаан бугын арьсаар өмд хийж, булганы арьсыг ихээр хэрэглэдэг. Эцэг, эх нь үхвэл эрэгтэй эмэгтэйчүүд олноороо 3 жил гашуудан үйлж шарилыг нь модон салаа дээр тавьдаг заншилтай⁵ хэмээн "Вэй улсын судар"-ын Шивэйгийн шастирт дурдсан нь Шивэй нарын эрхлэх аж ахуй, зан үйл, ёс заншил нь Монголчуудынхаас эрс өөр ялгаатай болохыг баталж байна. Шивэйгийн түүхийг судалсан Хятадын эрдэмтэд тэднийг угсаа гарлын хувьд нэгдмэл биш ч ихэвчлэн Манж, Түнгүс хэлтнүүд байсан хэмээн үздэг.⁶

Сүй улсын үе/581-618/ болоход Шивэйчүүд нь Өмнөд шивэй, Умард шивэй, Бо шивэй, Шэнмэда шивэй, Их шивэй гэсэн 5 их бүлэг болон хуваагдаж байсан тухай "Сүй улсын бичиг"-т нилээд дэлгэрэнгүй тэмдэглэн үлдээжээ.⁷

Тан улсын үе /618-907/ болоход Шивэйгийн хүн ам өсөн олширч, хорь гаруй аймагт хуваагдах болсон. Тан улсын үеийн Хятад сурвалжид дурьдагдаж байгаа хорь гаруй Шивэй аймгийн дотор Мэнгу шивэйгийн нэр анх тэмдэглэгджээ.

Бид "Хуучин Тан улсын түүх"-ийн шивэйгийн шастирт Мэнгу шивэй,⁸ "Шинэ Тан улсын түүх"-ийн шивэйгийн шастирт Мэнг ва шивэй⁹ нэрээр Шивэйгийн бүрэлдэхүүнд тэмдэглэгдсэн тэрхүү аймаг нь "Эргүнэ күн"-гийн домогт өгүүллэгддэг Монгол угсааны аймаг мөн бололтой. Өөрөөр хэлбэл, Жужан/Нирун/-ы хаант улс Түрэгүүдэд цохигдон мөхөхөд "Эргүнэ күн"-д шилжин суусан Жужан/Нирун/-ы ноёлох аймаг мөн хэмээн үзэж байна. Үүнийг дараах баримтууд болон логик гаргалгаанууд нотолж байна. Үүнд:

1. Хятад сурвалжид тэмдэглэгдсэн ханз болон дуудлагын ойролцоо байдлыг үндэслэн, Мэнгу гэдэг үгийг Монгол гэсэн үг мөн хэмээн үзэж байна. Сурвалжид тэмдэглэгдсэн Meng U 蒙兀 /Мэнгу/-гийн Meng 蒙 ханз нь орчин цагийн Хятад хэлэнд Meng Gu 蒙古 /Монгол/ гэхийг тэмдэглэдэг Meng ханзтай адил байна. Иймд Монгол гэдгийг ханзаар Meng U 蒙兀 гэж тэмдэглэсэн байх бүрэн боломжтой.

2. Хятад сурвалжид Мэнгу шивэйгийн нэр анх дурьдагдаж байгаа цаг үе нь Жужан /Нирун/-ы хаант улс мөхөж, Түрэгийн хаант улс Монголын нутагт байгуулагдан, Монгол угсааны аймгуудын түүх бүдэгрэн, сурвалж бичигт тэмдэглэгдэхээ байсан тэр үетэй давхцаж байна. Иймд Монгол угсааны зарим аймаг зүүн тийш нүүдэллэн Шивэй нарын нутагт очиж суусан байж болохоор байна.

3. Урьд өмнө Хятад сурвалжид Монгол /Мэнгу/ нэрээр огт тэмдэглэгдэж байгаагүй овог, аймаг юуны учир Шивэйгийн нутагт очиж суурьшсан хойноо Монгол /Мэнгу/ нэрээр Шивэй аймгийн нэг хэмээн тэмдэглэгдэх болов гэдэг асуудал гарч байна. Үүнийг тодруулахын тулд Монгол гэдэг үгний гарал үүсэл, утга агуулгыг мөшгөн судлах зайлшгүй шаардлагатай. Монгол гэдэг нэрийн гарал үүсэл, утга агуулгыг тайлбарласан маш олон хувилбар, саналууд байдаг боловч одоо хүртэл судлаачдын санал зөрөөтэй, ихэнх нь ямар нэгэн газар ус, уулын нэртэй холбон тайлбарласан нь үндэслэл баталгаа төдийлөн сайтай биш

байдаг. Харин доктор Б.Сумъяабазар, Г.Сүхбаатар, Н.Ишжамц, Сүрбадрах, С.Сиратори, Т.Фузида зэрэг эрдэмтэд "Монгол" гэдэг нэрийг Мугулюйтай холбон "Мухар" гэсэн үгнээс гаралтай хэмээн үзжээ.¹⁰ Бид "Монгол" гэдэг нэрийг Мугулюйгаас үүсэлтэй гэсэн саналыг дэмжиж байгаа бөгөөд овгийн толгойлогчийн нэрээс овог аймгийн нэр болсон байж болохоор байна. Жужан /Нирун/ улс мөхөхөд гол ноёлох аймгийн нэг байсан "Монгол" аймаг нь Түрэгийн захиргаанаас зайлан зүүн тийш нүүдэллэж, Шивэйгийн нутагт очиж сууснаар Мэнгу /Монгол/ шивэй нэрээр Хятадын сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ.

4. Их шивэй нь бусад Шивэйтэй "Үг хэл нэвтрэхгүй" хэмээн "Сүй улсын судар"-ын Шивэйгийн шастирт өгүүлжээ. Мэнгу шивэй нь Их Шивэйтэй хаяа нийлэн зэрэгцэн оршиж байсан учраас тухайн үед Мэнгу-г Их шивэйгийн нэгэн бүрэлдэхүүнээр үзэж, Их шивэйг бусад шивэйтэй адил үгүй гэж бичсэн бололтой. Мэнгу шивэй нь Түнгүс угсааны бусад Шивэй аймгуудтай үг хэл нэвтрэдэггүй төдийгүй Монгол угсааны аймаг байжээ. Харин дээр өгүүлсэн Хягантай хэл, эрхлэх аж ахуй, зан заншлын хувьд ойролцоо гэсэн Хятад сурвалжийн зарим мэдээ нь¹¹ Шивэйгийн нутагт очиж суусан Мэнгу шивэй зэргийг жишээ болгон харьцуулсан хэрэг байж болох юм.

5."Эргүнэ кун"-гийн домогт "эргэн тойрон уул хад, ой модоор хүрээлэгдсэн гаднаас ганцхан давчуу зөрөг замаар нэвтрэн орох" газарт очиж суусан тухай өгүүлдэг нь очиход бартаа саад ихтэй, алс бөглүү газар гэсэн утгыг илтгэсэн хэрэг хэмээн үзэж болохоор байна.Тэгвэл Мэнгу шивэй аймаг хаагуур нутаглаж байв, тэдний нутаг нь очиход бартаа саад ихтэй, тийм алс бөглүү газар байв уу ? үгүй юу ? гэдэг асуулт гарч ирж байна.

"Хуучин Тан улсын судар"-ын Шивэйгийн шастирт "Ван зиан хө /Ванцзяньхө/ гол нь Түрэгийн зүүн хойд зах дахь Зиүй мүн нуураас эх авч ... Мэнгу шивэйгийн умраар зүүнш урсана". "Шинэ Тан улсын судар"-ын Шивэйгийн шастирт "Ванзианьхө (Ванцзяньхө) гол нь Зиүй мүнээс эх авч... зүүнш урсана. Голын өмнө Мэнг ва/Мэнгу/ аймаг буй" гэжээ. Зиүй мүн нуур нь одоогийн Хөлөн нуур, Ванзианьхө гол гэдэг нь одоогийн Эргүнэ гол мөн гэж судлаачид үзэж байна."Сүй улсын бичиг"-ийн Шивэйгийн шастирт Мэнгу шивэйгийн нутагт очиход "Явах зам нь бэрх бартаа ихтэй" гэсэн нь Их Хянганы давааны бартаатай уул нуруу, ой хөвчийг хэлсэн байж болохоор байна.Энэ бүгдээс үзвэл Мэнгу шивэй нь Эргүнэ голын өмнө хөвөө, Хянганы давааны Умард хэсгийн баруун бэлээр нутаглаж байжээ. Энэ газар нь газар зүйн байршил, орчин нөхцөлөөрөө " Эргүнэ кун" мөн байж болохоор байна.

Эндээс үзэхэд "Тан улсын судар"-т тэмдэглэгдсэн Мэнгу шивэй нь Түнгүс угсааны Шивэй аймаг бус, харин Түрэгүүдэд цохигдон зүүн тийш шахагдаж, Шивэй аймгуудын нутагт шилжин суусан Монгол аймаг байсан байна¹². Шивэйгийн нутагт шилжин суусан Монгол аймгийг Хятад сурвалжуудад Шивэй аймгуудын нэг хэмээн үзэж Мэнгу (Монгол) шивэй нэрээр тэмдэглэн үлджээ. Үүнээс үүдэн Хятад сурвалжийн дээрх мэдээнд тулгуурлан ихэнх судлаачид Шивэй нарыг бүхэлд нь монгол угсааны аймгууд¹³ гэж үзэх, эсвэл зарим судлаачид Шивэй аймгууд бүхэлдээ Манж Түнгүс гаралтай гэсэн үзлийг одоо хүртэл баримталсаар байна. Энэхүү монгол аймаг нь Шивэйгийн нутгаас нүүдэллэн гарч, төрөлх нутаг Онон мөрний эх Бурхан Халдун ууланд эргэн ирж, Хамаг Монголын хаант улсыг байгуулан, улмаар Их Монгол улсын гол мөхлөг, Халхчуудын өвөг дээдэс болсон билээ.

Ишлэл зүйлт.

1. Рашид-Ад-Дин Сборник летописей. Книга 1, Т.1.М., 1952. стр 153-154
2. Д.Гонгор. Халх товчоон. I боть. УБ., 1970. 45-р тал; БНМАУ-ын түүх. I боть. УБ., 1996. 169-170-р тал.
3. Х. Пэрлээ. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь УБ, 1959. 12-р тал.
4. Мөн тэнд. 13-р тал.
5. Вэй улсын судар" /Вэй Шү/- ын Шивэйгийн шастир. {Хятадаар}
6. Лин Ган "Дунхугийн түүх" Хөх хот., 1997. 375-р тал; Сундуй. Мончууд. Хөх хот., 1998. 91-96-р тал.
7. "Сүй улсын судар"/Сүй шү/-ын Шивэйгийн шастир. {Хятадаар}
8. "Хуучин Тан улсын судар"/Зиү Тан шү/-ын Шивэйгийн шастир. {Хятадаар}
9. "Шинэ Тан улсын судар"/Синь Тан шү/-ын Шивэйгийн шастир. {Хятадаар}
10. Г.Сүхбаатар "Монгол Нирун улс" УБ., 1992. 76-80-р тал.
11. Х. Пэрлээ. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь. УБ, 1959. 12-р тал.
12. П.Дэлгэржаргал.Шивэй аймгуудын угсаа-түүхийн зарим асуудал.МУИС-ийн Эрдэм Шинжилгээний Бичиг.УБ.,2001.№8/174/. 107-115-р тал
13. БНМАУ-ын түүх. I боть. УБ.,1966. 169-170-р тал; Х.Пэрлээ.Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь.УБ.,1959. 12-13-р тал